



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/23

Мөрөн сум

Ахмадын асрамжийн байнгын үйлчилгээнд  
хамруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэн Цэвээний Нацаг (РВ40041536) нь үр хүүхэдгүй, харж хандах хүнгүй, өөрийн гэсэн орон гэргүй, байнгын асаргаанд байх шаардлагатай, ганц бие ахмад настан тул Ахмад настны асрамж үйлчилгээний төвд 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн байнгын асрамжийн үйлчилгээнд хамруулахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн даргын албан үүргийг түр гүйцэтгэгч (Т.Октябрьбаяр)-д даалгасугай.

2. Тухайн иргэнийг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвд хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулахыг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ